


## 2019 оны 08 дугаар сарын цаг агаарын тойм

### а. Агаарын температур


2019 оны 08 дугаар сарын агаарын **дундаж температур** Монголын 70 өртөөдийн дунджаар  $17.3^{\circ}\text{C}$  буюу олон жилийн дунджаас  $0.7^{\circ}\text{C}$ -аар дулаан байв. Сарын дундаж температурыг 1981-2010 оны дундажтай харьцуулбал: Баруун аймгуудын нутгаар Төвийн аймгуудын баруун хэсгээр дулаан. Сүхбаатар, Дорнод аймгийн ихэнх нутгаар дунджаас сэрүүн. Бусад нутгаар дунджийн орчим байв /*зураг-1*/.



Зураг-1. 2019 оны 08 дугаар сарын агаарын дундаж температурын хазайц( $^{\circ}\text{C}$ )

08 дугаар сарын агаарын үнэмлэхүй бага температур Алтай, Хангайн уулархаг нутгаар  $0..-5^{\circ}\text{C}$ , Алтайн өвөр говь болон Говийн бүс нутгийн өмнөд хэсгээр  $10..15^{\circ}\text{C}$ , бусад нутгаар  $0..10^{\circ}\text{C}$  байсан ба тухайн сард хамгийн үнэмлэхүй бага температур шөнөдөө Баянхонгор аймгийн Гурванбулаг суманд  $-5.2^{\circ}\text{C}$  хүрсэн байна /*зураг-2*/.


Агаарын хамгийн бага температур (2019/08/01 - 2019/08/31)



Зураг-2. 2019 оны 08 дугаар сарын агаарын үнэмлэхүй бага температур/ $^{\circ}\text{C}$ /

**08** дугаар сарын агаарын үнэмлэхүй **их температур** Алтай, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар 19-24°C, Алтайн өвөр говь, Монгол Дорнодын тал нутгаар 34°C...39°C , бусад нутгаар нутгаар 25°C...34°C дулаан байсан ба тухайн сард агаарын үнэмлэхүй хамгийн их температур Баянхонгор аймгийн Эхийн гол орчмоор **39°C** градус мөн Дорнод аймгийн Сэргэлэн суманд **39.1°C** хүрсэн байна. /**зураг-3**/

?????? ?????? ?? ????????? (2019/08/01 - 2019/08/31)




**Зураг-3. 2019 оны 08 дугаар сарын агаарын үнэмлэхүй их температур\°C\**

**б. Хур тунадас**

Хур тунадасны нийлбэрийг авч үзвэл: Булган, Хэнтий, Сүхбаатарын зарим газраар Өвөрхангай, Дундговь, Дорноговийн хойд хэсгээр, Сэлэнгэ, Төв, Дорнодын ихэнх нутгаар 60-151.7 мм. Баян-Өлгий, Увсын өмнөд, Завхан, Баянхонгорын баруун хэсгээр, Ховд, Говь-Алтайн ихэнх нутгаар 0,1-10 мм, бусад нутгаар 11-59.0 мм бороо орсон буюу Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг орчмоор **151.7мм** тунадас орсон байна. /**зураг-4**/.


Хур тунадас (2019/08/01 - 2019/08/30)



**Зураг-4. 2019 оны 08 дугаар сард орсон хур тунадасны нийлбэр\мм\**

**08** дугаар сард орсон хур тунадсыг уур амьсгалын дундажтай харьцуулбал: Баян-Өлгийн хойд хэсэг, Хэнтий, Сүхбаатарын өмнөд, Өмнөговь, Дорнодын зүүн, Төв, Дорноговийн ихэнх нутгаар дунджаас ахиу, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Хөвсгөл, Архангай, Булганы ихэнх нутгаар, Баян-Өлгийн өмнөд, Сэлэнгийн баруун, Хэнтийн хойд хэсгээр дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас оров /**зураг-5**/.

Precipitation anomaly 2019-08




**Зураг-5.** 2019 оны **08** дугаар сард орсон хур тунадасны хазайц\%\

**в. Салхи**

**08** дугаар сард салхины үнэмлэхүй дундаж их хурд Алтайн өвөр говь, Говь, Талын нутгаар 12-24м/с, бусад нутгаар 8-12м/с хүрч ширүүссэн. Салхины үнэмлэхүй хамгийн их Говь-Алтай аймгийн Алтай суманд түр зуур **27м/с** хүрсэн байна /**зураг-6**/.

Салхины хамгийн их хурд (2019/08/01 - 2019/08/31)



**Зураг-6.** 2019 оны **08** дугаар сард ажиглагдсан салхины дундаж их хурд\м/с\